| <b>2133</b> | <b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>                                                         |            | <b>5,992,000.00</b>  |
| 213305      | Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг                                                                 |            | 5,992,000.00         |
| <b>22</b>   | <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                                                                                    |            | <b>00.00</b>         |
| <b>II</b>   | <b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>                                                                      |            | <b>17,642,000.00</b> |
| <b>1311</b> | <b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>                                                                         |            | <b>17,642,000.00</b> |
| 131104      | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө |            | 17,124,000.00        |
| 131105      | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               |            | 518,000.00           |



### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монголын театрын музейн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах, хөрөнгийн ангилал зөв бүртгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 25-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Уваа уул аудит ХХК-ийн аудитор Ц.Саранцэцэг, аудиторын туслах Э.Номинчулуун, Г.Сампилмаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ч.Мөнхтуяа хэрэгжүүлсэн.

Монголын театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монголын театрын музейн зорилго нь Урлаг, соёлын өвийг хадгалж хамгаалан хойч үедээ уламжлуулж, иргэдийн оюуны тодорхой эрэлт хэрэгцээг хангах, улмаар нийгмийн хөгжилд үр нөлөө үзүүлэхэд оршино.

Тус байгууллага нь тайз, дэлгэцийн урлагийн холбогдолтой нандин цуглуулгыг хадгалах, хамгаалах, судлах, хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, үзэсгэлэн гаргах, судлаач уран бүтээлчидтэй хамтран ажиллах, үндэсний болон олон улсын хэмжээнд үзэгчдийг аялах боломжийг бий болгох талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Монголын театрын музей нь БСШУС-ын 2017 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн “Бодлогын баримт бичиг, журам батлах тухай” А/40 тоот тушаалын хүрээнд бэлтгэсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллаж байна. Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монголын театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 199,909.6 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,999.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Монголын театрын музейн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,275.5 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн дансдууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт                                              | Эхний<br>үлдэгдэл | Эцсийн<br>үлдэгдэл | Өөрчлөлт       |
|-------------------------------------------------------|-------------------|--------------------|----------------|
| Б                                                     | 1                 | 2                  | 3=2-1          |
| Авлага                                                | 00.00             | 8,842.0            | 8,842.0        |
| Бараа материал                                        | 8,368.8           | 9,457.2            | 1,088.4        |
| Үндсэн хөрөнгө                                        | 826,793.3         | 825,138.4          | (1,654.9)      |
| <b>Нийт хөрөнгө</b>                                   | <b>835,162.1</b>  | <b>843,437.6</b>   | <b>8,275.5</b> |
| Засгийн газрын хувь оролцоо                           | 835,162.1         | 843,437.6          | 8,275.5        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө<br/>өмчийн дүн</b> | <b>835,162.1</b>  | <b>843,437.6</b>   | <b>8,275.5</b> |

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Бараа материал дансны үлдэгдэл 9,457.2 мянган төгрөг болж, 1,088.4 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор бараа материал худалдаж авсантай холбоотой байна;
- Авлага дансны үлдэгдэл 8,842.0 мянган төгрөгөөр өссөн нь цар тахалтай холбоотой хил гааль хаагдсанаас болж 2,850.0 мянга, эрх нээгдэх боломжгүй цаг хугацаанд буюу оны сүүлд 5,992.0 мянган төгрөгийн санхүүжилт орсноос зарцуулалт хийгдээгүй, төсөвт төвлөрүүлж авлагаар тусгасан байна;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 825,138.4 мянган төгрөг болж, 1,654.9 мянган төгрөгөөр буурсан нь 4,564.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, ТӨБЗГ-ын 2021 оны 560, 593 дугаар шийдвэрийн дагуу 25,745.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж устган, элэгдлээ нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинээр тогтоож, 1,983.0 мянган төгрөгийн орлого авсан, үнэ төлбөргүй 1,849.4 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс хувь хүнээс 1,408.0 мянган төгрөгийн түүх соёлын дурсгалт зүйл, 441.4 мянган төгрөгийн ном Соёлын яамнаас ирсэн, тайлант хугацаанд 10,051.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна;

- Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 843,437.6 мянган төгрөг болж 8,275.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Монголын театрын музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос оноос 30,898.5 мянган төгрөгөөр буюу 15.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт 18,822.1 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 17,642.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт олгосонтой холбоотой байна.

Нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 21,720.9 мянган төгрөгөөр буюу 10.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл 3,627.4 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал 17,983.3 мянган төгрөгөөр өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны санхүүжилтийн эх үүсвэрийг 218,353.8 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 218,353.8 мянган төгрөг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс дээд шатны төсвийн захирагч тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан, 28,744.3 мянган төгрөгөөр бууруулан, 189,609.5 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсөв хүрэлцэхгүй байснаас нэмж тодотгох хүсэлт гаргасны улмаас 18,822.0 мянган төгрөгөөр нэмж төсвийг тодотгосон байна.

Төсвийн тодотголоор санхүүжилтийн эх үүсвэрийг 208,431.5 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 208,431.5 мянган төгрөгийн зарцуулахаар баталсан.

Үндсэн үйл ажиллагаанаас /үзвэрийн тасалбарын/ орох орлогын төлөвлөгөө батлагдаагүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 208,431.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 208,431.5 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч, урсгал үйл ажиллагаанд 208,025.8 мянган төгрөгийг зарцуулж, 405.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 208,025.8 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь Цалин хөлс болон нэмэгдэл урамшил 11.9 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл НДШ 379.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж зардлыг 4.4 мянган төгрөг, нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг 10.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээний |                               | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|-----|--------------------------|-------------------------------|------------|-----------|-------|---------|
|     | Код                      | Нэр                           |            |           |       |         |
| 1   | 71702                    | Соёл урлаг                    | 208,431.5  | 208,025.8 | 405.7 | 99.8    |
| 1.1 | 80101                    | Үндсэн үйл ажиллагааны зардал | 203,539.9  | 203,147.8 | 391.3 | 99.8    |
| 1.2 | 80215                    | Эрдэм шинжилгээ               | 903.6      | 903.6     | 0.0   | 100.0   |
| 1.3 | 80219                    | Харуул хамгаалалт             | 2,400.0    | 2,396.4   | 4.4   | 99.8    |

|     |       |                                          |         |         |      |       |
|-----|-------|------------------------------------------|---------|---------|------|-------|
| 1,4 | 81909 | Музейн түүх соёлын өвийг сэргээх         | 328.0   | 328.0   |      | 100.0 |
| 1.5 | 80802 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал | 1,260.0 | 1,250.0 | 10.0 | 99.2  |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас 3 төслийн 17,124.0 мянга, үзвэрийн тасалбарын орлого 518.0 мянга, нийт 17,642.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 1,900.0 мянга, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 2,400.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 300.0 мянга, эд хогшил худалдан авахад 4,632.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 1,900.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 518.0 мянга, нийт 11,650.0 мянган төгрөгийг зарцуулж, 5,992.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлснийг авлагаар тусгасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Монголын театрын музей нь үндсэн 10 ажилтантай. Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 5 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.8 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас авсан судалгааг нэгтгэн дүгнэхэд байгууллагын 30 жилийн ойн хүлээн авалтад 7,125.0 мянган төгрөг зарцуулсан байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг төлөвлөдөггүй, дээд шатны төсөв захирагч хянахдаа мөн нэмж батлаагүй байна. Иймээс үндсэн үйл ажиллагаанаас орсон тасалбарын орлогыг нэмэлт санхүүжилтээр тайлагнаж байна.

Санхүүгийн тайлангийн программын алдаанаас шалтгаалан 72,399.1 мянган төгрөгийн “Түүх соёлын дурсгалт зүйлс” үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналд татагдаагүй байсныг залруулга хийлгэсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монголын театрын музей 2021 онд нийт 221,820.0 мянган төгрөгийн 149 мэдээг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 59,856.1 мянган төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн төсөл боловсруулахдаа төсвийн байгууллагын үйл ажиллагаанаас орох орлогыг төлөвлөдөггүй, дээд шатны төсөв захирагч хянахдаа нэмж батлаагүй нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалын 3.4.3-д үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах” заалттай нийцэхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 88,120.9 мянган төгрөгийн 14 алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Өгсөн зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад дансны бичилт буруу хийсэн, журналын дүн анхан шатны баримтын дүнгээс зөрүүтэй, хөрөнгийн ангилал буруу хийсэн, төсвийн гүйцэтгэлийн тайлан, нэмэлт санхүүжилтийн тайлан зөв бэлтгээгүй зэрэг 86,336.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан байна. Харин тушаал шийдвэргүй 1,784.7 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон зөрчлийг арилгаагүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 30,070.1 мянган зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2,617.4 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна. Харин шилэн дансны цахим хуудсанд байршуулах 18 мэдээг хугацаа хоцроож байршуулсан зөрчилд өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 85.9 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт-3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/*

| Үзүүлэлт        | Өмнөх оны илрүүлэлт |                 | Биелэлт  |                 | Зөрүү    |          |             |
|-----------------|---------------------|-----------------|----------|-----------------|----------|----------|-------------|
|                 | Тоо                 | Дүн             | Тоо      | Дүн             | Тоо      | Дүн      | Хувь        |
| Албан шаардлага | 1                   | 30,070.1        | 1        | 30,070.1        | -        | -        | 100.0       |
| Зөвлөмж         | 3                   | 2617.4          | 2        | 2,617.4         | -        | -        | 92.5        |
| <b>Нийт дүн</b> | <b>4</b>            | <b>32,687.5</b> | <b>3</b> | <b>32,687.5</b> | <b>-</b> | <b>-</b> | <b>96.2</b> |

Өмнөх оны зөвлөмжийг хэрэгжүүлээгүй шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд ил тод байршуулаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Үндсэн үйл ажиллагаанаас орох үзвэрийн тасалбарын орлогын төлөвлөлт болон тасалбарын орлогыг цахимжуулах бэлтгэл ажлын хүрээнд нэмэлт санхүүжилтээр техник хэрэгсэл худалдан авч 2022 оноос энэ ажлыг хэрэгжүүлж эхлэх учир үр дүнг дараагийн аудитаар үзэх шаардлагатай.



#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31,798.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 11,947.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,361.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 13,506.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,983.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгөв.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн дүн 19,850.8 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 1,999.1 мянган төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгээс буцаан авах 5,992.0 мянган төгрөгийг авлагаар бүртгээгүй;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг 405.7 мянган төгрөгийг тохируулаагүй;
- Цалингийн урьдчилгаа 5,550.0 мянган төгрөгийг шууд цалингийн өглөгт бичсэнийг тус тус залруулга хийлгэв.

##### 4.2 Төлбөрийн акт

Тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэлд 3,267.1 мянган төгрөг, 2020 онд тус байгууллагад ажиллаагүй нягтлан бодогч, нярав нарт 2020 оны аудитын дүгнэлтийг үндэслэн урамшуулалд 1,094.7 мянган төгрөг үндэслэлгүй олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;" 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 3.2-д "... Төсвийн зардлыг батлагдсан төсөв, зарцуулалтын эрхийн баталгаа, эрх бүхий байгууллагын шийдвэр, гэрээг үндэслэж гарсан зардлыг анхан шатны баримтыг үндэслэн хүлээн зөвшөөрч бүртгэнэ." заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

##### 4.3 Албан шаардлага

Байгууллагын 30 жилийн ойн хүлээн авалтад 7,125.0 мянган төгрөг зарцуулсан, нийт ажилтнуудад тушаал гарган, ур чадварын нэмэгдэл 25 хувиар, үр дүнгийн урамшуулал 40 хувиар хавтгайруулан 6,381.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах," 1.6-д "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх," заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

##### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

1,983.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тавилга эд хогшил, бусад үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга, УСНББОУС 17

Үндсэн хөрөнгө, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-тай нийцэхгүй, “үнэлгээ ба хуваарилалт”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

УСНББОУС 1, 17, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалыг мөрдөн ажиллаж, дансны ангилал зөв бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Монголын театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| №                               | Ба<br>йгу<br>ул<br>лаг<br>ын<br>нэр | Аудитын<br>код                          | Алдаа, зөрчлийн товч утга                                                                                                                                                                                                                          | Аудитын<br>байгууллагын<br>тогтоосон акт,<br>албан шаардлага,<br>өгсөн зөвлөмж,<br>залруулгын товч<br>утга | Нийт алдаа<br>зөрчил |          | Залруулга |         | Төлбөрийн<br>акт |         | Албан<br>шаардлага |     | Зөвлөмж |         |
|---------------------------------|-------------------------------------|-----------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------|----------|-----------|---------|------------------|---------|--------------------|-----|---------|---------|
|                                 |                                     |                                         |                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                            | Тоо                  | Дүн      | Тоо       | Дүн     | Тоо              | Дүн     | Тоо                | Дүн | Тоо     | Дүн     |
| Санхүүгийн тайлангийн асуудлаар |                                     |                                         |                                                                                                                                                                                                                                                    |                                                                                                            |                      |          |           |         |                  |         |                    |     |         |         |
| 1                               | МТМ<br>узей                         | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | Тушаал шийдвэргүйгээр ур<br>чадварын нэмэгдэлд 3,267.1<br>мянган төгрөг, 2020 онд тус<br>байгууллагад ажиллаагүй нягтлан<br>бодогч, нярав нарт 2020 оны<br>аудитын дүгнэлтийг үндэслэн<br>урамшуулалд 1,094.7 мянган<br>төгрөг үндэслэлгүй олгосон | Төлбөрийн акт<br>тогтоох                                                                                   | 1                    | 4,361.8  |           |         | 1                | 4,361.8 |                    |     |         |         |
| 2                               | МТМ<br>узей                         | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | Байгууллагын 30 жилийн ойн<br>хүлээн авалтад 7,125.0 мянган<br>төгрөг зарцуулсан, нийт<br>ажилтнуудад тушаал гарган, ур<br>чадварын нэмэгдэл 25 хувиар, үр<br>дүнгийн урамшуулал 40 хувиар<br>хавтгайруулан 6,381.0 мянган<br>төгрөг олгосон       | Зөрчлийг арилгаж,<br>давтан гаргахгүй<br>байх талаар албан<br>шаардлага бичих                              | 1                    | 13,506.0 |           |         |                  | 1       | 13,506.0           |     |         |         |
| 3                               | МТМ<br>узей                         | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | 1,983.0 мянган төгрөгийн тоног<br>төхөөрөмжийг тавилга эд хогшил,<br>бусад үндсэн хөрөнгийн дансанд<br>бүртгэсэн                                                                                                                                   | Хөрөнгийн ангилал<br>зөв хийх зөвлөмж<br>өгөх                                                              | 1                    | 1,983.0  |           |         |                  |         |                    |     | 1       | 1,983.0 |
| 4                               | МТМ<br>узей                         | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | Цалингийн урьдчилгаа 5,550.0<br>мянган төгрөгийг шууд цалингийн<br>өглөгт бичсэн                                                                                                                                                                   | Цалингийн<br>урьдчилгаа<br>дансанд залруулав                                                               | 1                    | 5,550.0  | 1         | 5,550.0 |                  |         |                    |     |         |         |

**Монголын театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

|                                                                 |             |                                         |                                                                                                                                                                                                        |                                                                               |   |          |   |          |   |         |   |          |   |         |
|-----------------------------------------------------------------|-------------|-----------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|---|----------|---|----------|---|---------|---|----------|---|---------|
| 5                                                               | МТМ<br>узей | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | Нэмэлт санхүүжилтийн<br>төвлөрүүлэх шилжүүлгээс буцаан<br>авах 5,992.0 мянган төгрөгийг<br>авлагаар бүртгээгүй;                                                                                        | Авлага дансанд<br>залруулав                                                   | 1 | 5,992.0  | 1 | 5,992.0  |   |         |   |          |   |         |
| 6                                                               | МТМ<br>узей | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | Төсвийн гүйцэтгэлийн тайланд<br>төвлөрүүлэх шилжүүлэг 405.7<br>мянган төгрөгийг тохируулаагүй;                                                                                                         | Төсвийн<br>гүйцэтгэлийн<br>тохируулга<br>хийлгэж залруулав                    | 1 | 405.7    | 1 | 405.7    |   |         |   |          |   |         |
| <b>Санхүүгийн аудитын ДҮН</b>                                   |             |                                         |                                                                                                                                                                                                        |                                                                               | 6 | 31,798.5 | 3 | 11,947.7 | 1 | 4,361.8 | 1 | 13,506.0 | 1 | 1,983.0 |
| <b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал</b> |             |                                         |                                                                                                                                                                                                        |                                                                               |   |          |   |          |   |         |   |          |   |         |
| 1                                                               | МТМ<br>узей | АХГ-<br>2022/19<br>8/НА-<br>СТА-<br>ТШЗ | Нийт 221,820.0 мянган төгрөгийн<br>149 мэдээг Шилэн дансны<br>нэгдсэн цахим хуудаст ил тод<br>байршуулахаас 59,856.1 мянган<br>төгрөгийн 18 мэдээллийг хугацаа<br>хоцроож мэдээлсэн зөрчилтэй<br>байна | Зөрчлийг арилгах,<br>давтан гаргахгүй<br>байх талаар албан<br>шаардлага өгсөн | 1 | 59,856.1 |   |          |   |         | 1 | 59,856.1 |   |         |
| <b>Нийцлийн асуудлын ДҮН</b>                                    |             |                                         |                                                                                                                                                                                                        |                                                                               | 1 | 59,856.1 |   |          |   |         |   |          |   |         |
| <b>НИЙТ ДҮН</b>                                                 |             |                                         |                                                                                                                                                                                                        |                                                                               | 7 | 91,654.6 | 3 | 11,947.7 | 1 | 4,361.8 | 2 | 73,362.1 | 1 | 1,983.0 |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022

оны

02

дугаар сарын

25

№

44/A0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/128/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 10 хүнд тушаал шийдвэргүйгээр 3,267,100.00 төгрөгийн ур чадварын нэмэгдэл, мөн 2020 онд тус байгууллагад ажиллаагүй нягтлан бодогч, няравт 2020 оны балансын урамшуулал 1,094,700.00 төгрөгийг үндэслэлгүй олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх," 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах," 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон нийт 4,361,800.00 /дөрвөн сая гурван зуун жаран нэгэн мянга найман зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнуудаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монголын театрын музейн захирал Д.Наранжаргал, нягтлан бодогч И.Солонго нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ

"УВАА УУЛ АУДИТ" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА



Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Akt\2022\0225 Auditin 4 Gazar-44.Docx

001090153



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 254/А0150458

Улаанбаатар хот

БХГ-2022/198/НА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын Театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 30 жилийн ойн хүлээн авалтад 7,125,000.00 төгрөг зарцуулсан, мөн нийт ажилтнуудад үр чадварын нэмэгдэл 25 хувиар, үр дүнгийн урамшууллыг 40 хувиар хавтгайруулан 6,381,000.00 төгрөг тус тус илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн хөрөнгийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монголын Театрын музейн захирал Д.Наранжаргал, нягтлан бодогч И.Солонго нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ,

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Ч.МӨНХТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120396

1110.10.10.2018.0001\_Karreg\Alban Shoardlaga\2022\0225 Auditin 2 Gazar-238.Docx

0010800756



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 253/А0150458  
АХГ-2022/198/НА-АН-ТМЗ

Улаанбаатар хот

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Монголын Театрын музейн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар өгсөн шилэн дансны цахим системд мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг хангаж ажиллах албан шаардлагын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, тайлант онд зөрчлийг давтан гаргаж, байгууллагын шилэн дансны цахим мэдээллийн санд байршуулбал зохих 149 мэдээллээс 18 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3."Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллаж, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага хэрэгжүүлээгүй албан тушаалтанд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлэхийг Монголын Театрын музейн захирал Д.Наранжаргал даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ  
АУДИТЫН МЕНЕЖЕР С.НАЦАГДОРЖ  
УВАА УУЛ АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч.МӨНХТУЯА

[illegible]

[illegible]



[illegible]